

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	13
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	17
Залруулсан алдаа.....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	18
4. Менежментийн захидал	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 29 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.ОЮУНСУВД ТАНАА

2021.02.25 № 07/478
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулаагүй, 230,177.6 мянган төгрөгийн хоол хүнсний материал худалдан авах болон үдийн цайны үйлчилгээний тендерийг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй зэрэг зөрчлүүд нь хууль эрх зүйн акт, санхүүгийн тайлагналын “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/Төгрөгөөр/	
Дансны код	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	<u>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ</u>	00.00	00.00
33	<u>АВЛАГА</u>	924,567.00	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	924,567.00	00.00
35	<u>БАРАА МАТЕРИАЛ</u>	82,232,015.55	91,747,076.96
351	<u>Түүхий эд материал</u>	15,517,910.65	13,899,735.15
35130	Эм боох материал	15,517,910.65	13,899,735.15
354	<u>Хангамжийн материал</u>	66,714,104.90	77,847,341.81
35410	Бичиг хэргийн материал	2,138,830.00	1,671,350.00
35420	Аж ахуйн материал	4,547,500.00	4,248,665.00
35440	Түлш, шатах тослох материал	5,597,220.00	3,276,800.00
35450	Барилгын засварын материал	5,094,850.00	1,451,500.00
35460	Хүнсний материал	1,742,989.00	261,900.00
35470	Бусад хангамжийн материал	47,592,715.90	66,937,126.81
1	<u>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</u>	83,156,582.55	91,747,076.96
39	<u>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</u>	4,745,461,041.06	4,726,755,197.17
392	<u>Биет хөрөнгө</u>	4,199,996,721.06	4,181,290,877.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,082,676,048.00	4,082,676,048.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(173,021,420.04)	(276,103,240.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	126,974,891.00	126,974,891.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(44,684,422.13)	(49,379,625.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	523,697,558.22	553,330,634.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	(390,640,467.66)	(438,832,441.48)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	177,384,932.47	178,024,932.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	(135,274,785.21)	(147,513,955.73)
39214	Бусад үндсэн хөрөнгө	98,746,354.40	219,362,587.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(86,486,985.44)	(87,873,970.88)
39217	Ном	20,625,017.45	20,625,017.45
393	<u>Биет бус хөрөнгө</u>	545,464,320.00	545,464,320.00
39301	Программ хангамж	1,540,000.00	1,540,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,540,000.00)	(1,540,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	545,464,320.00	545,464,320.00
2	<u>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</u>	4,745,461,041.06	4,726,755,197.17
3	<u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</u>	4,828,617,623.61	4,818,502,274.13
5	<u>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</u>	4,828,617,623.61	4,818,502,274.13
51	<u>Засгийн газрын хувь оролцоо</u>	4,828,617,623.61	4,818,502,274.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,767,655,847.77	2,767,655,847.77
51101	Өмч: - төрийн	2,767,655,847.77	2,767,655,847.77
512	<u>Хуримтлагдсан үр дүн</u>	(976,602,800.50)	(986,718,149.98)
51210	Өмнөх үеийн үр дүн	(976,602,800.50)	(976,602,800.50)
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(10,115,349.48)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,037,564,576.34	3,037,564,576.34
6	<u>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</u>	4,828,617,623.61	4,818,502,274.13

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	/Төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>2,984,526,567.00</u>	<u>3,134,538,670.91</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,764,567.00	147,881,470.91
120	Нийтлэг татварын бус орлого	924,567.00	00.00
120009	Бусад орлого	924,567.00	00.00
122	Тусламжийн орлого	5,840,000.00	147,881,470.91
122001	Хандив тусламж /дотоод/	5,840,000.00	147,881,470.91
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>2,977,762,000.00</u>	<u>2,986,657,200.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,964,506,600.00	2,983,959,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,964,506,600.00	2,983,959,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,255,400.00	2,697,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,255,400.00	625,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,072,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>3,127,900,393.64</u>	<u>3,144,654,020.39</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,127,900,393.64	3,144,654,020.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,619,717,496.79	2,686,447,267.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,934,089,436.35	2,031,724,728.51
210101	Үндсэн цалин	1,934,089,436.35	1,531,073,205.51
210102	Нэмэгдэл	00.00	418,881,157.00
210104	Урамшуулал	00.00	81,770,366.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,743,626.83	269,917,657.87
210201	Тэтгэврийн даатгал	102,551,868.43	194,646,763.95
210202	Тэтгэмжийн даатгал	11,675,628.90	20,768,509.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,311,944.06	15,485,424.80
210204	Ажилгүйдлийн даатгал	3,924,325.30	5,401,541.10
210205	Эрүүл мэндийн даатгал	18,279,860.14	33,615,418.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	110,776,009.47	86,029,440.29
210301	Гэрэл, цахилгаан	28,979,805.00	20,009,267.00
210302	Түлш, халаалт	42,488,568.21	46,744,108.29
210303	Цэвэр, бохир ус	39,307,636.26	19,276,065.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,840,015.00	34,078,052.00
210401	Бичиг хэрэг	5,321,310.00	5,051,075.00
210402	Тээвэр, шатахуун	11,827,800.00	7,470,220.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,387,500.00	3,631,320.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,775,920.00	2,628,720.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,527,485.00	15,296,717.00

2105	Нормативт зардал	150,129,371.40	54,794,715.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,538,754.00	6,451,915.50
210502	Хоол, хүнс	141,886,617.40	48,342,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	704,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,673,040.00	20,350,850.00
210604	Урсгал засвар	21,673,040.00	20,350,850.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,540,302.00	18,868,670.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,231,802.00	17,239,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	278,820.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	387,500.00	484,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	921,000.00	866,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	184,925,695.74	170,683,152.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,501,650.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,117,280.00	1,088,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	172,306,765.74	169,595,152.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	508,182,896.85	458,206,753.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	95,609,200.00	163,298,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	93,367,200.00	162,698,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,242,000.00	600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	412,573,696.85	294,908,653.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	412,573,696.85	294,908,653.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-143,373,826.64</u>	<u>-10,115,349.48</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-143,373,826.64</u>	<u>-10,115,349.48</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	/Төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,978,686,567.00</u>	<u>2,987,581,767.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	924,567.00	924,567.00
120	Нийтлэг татварын бус орлого	924,567.00	924,567.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	924,567.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	924,567.00
120009	Бусад орлого	924,567.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>2,977,762,000.00</u>	<u>2,986,657,200.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	<u>2,964,506,600.00</u>	<u>2,983,959,600.00</u>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,964,506,600.00	2,983,959,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,255,400.00	2,697,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,255,400.00	625,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,072,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,978,686,567.00</u>	<u>2,983,126,867.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,978,686,567.00	2,983,126,867.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,369,061,543.15	2,501,535,733.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,865,331,201.90	2,050,708,707.64
210101	Үндсэн цалин	1,529,196,502.90	1,110,822,043.79
210102	Нэмэгдэл	224,648,699.00	835,034,451.85
210104	Урамшуулал	111,486,000.00	104,852,212.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	212,501,861.28	250,933,678.74
210201	Тэтгэврийн даатгал	197,193,291.28	177,598,103.40
210202	Тэтгэмжийн даатгал	15,308,570.00	18,768,396.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	13,157,894.35
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	3,171,423.14
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	38,237,860.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	110,776,009.47	86,029,440.29
210301	Гэрэл, цахилгаан	28,979,805.00	20,009,267.00
210302	Түлш, халаалт	42,488,568.21	46,744,108.29
210303	Цэвэр, бохир ус	39,307,636.26	19,276,065.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58,037,187.00	31,443,987.00
210401	Бичиг хэрэг	6,203,000.00	4,530,595.00
210402	Тээвэр, шатахуун	13,772,300.00	5,149,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,387,500.00	3,595,320.00
210404	Ном, хэвлэл	8,113,900.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,775,920.00	3,528,720.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,784,567.00	14,639,552.00
2105	Нормативт зардал	59,972,371.50	32,838,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,571,771.50	4,702,070.00
210502	Хоол, хүнс	39,534,100.00	21,870,630.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,866,500.00	6,265,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,159,840.00	17,962,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	813,000.00
210602	Тавилга	1,560,000.00	00.00
210604	Урсгал засвар	26,599,840.00	17,149,700.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,650,262.00	26,935,870.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,341,762.00	25,306,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	278,820.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	387,500.00	484,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	921,000.00	866,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,632,810.00	4,682,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,889,730.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,743,080.00	4,682,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	609,625,023.85	481,591,133.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	196,126,760.00	186,682,480.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	100,517,560.00	23,384,380.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	93,367,200.00	162,698,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,242,000.00	600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	413,498,263.85	294,908,653.33
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	294,763,153.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	413,498,263.85	00.00
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлсэн шилжүүлэг	00.00	145,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	4,454,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	4,454,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	4,454,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	4,454,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	4,454,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-4,454,900.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,767,655,847.77	3,037,564,576.34	(833,228,973.86)	00.00	4,971,991,450.25
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,767,655,847.77	3,037,564,576.34	(833,228,973.86)	00.00	4,971,991,450.25
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	00.00	(143,373,826.64)	00.00	(143,373,826.64)
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,767,655,847.77	3,037,564,576.34	(976,602,800.50)	00.00	4,828,617,623.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,767,655,847.77	3,037,564,576.34	(976,602,800.50)	00.00	4,828,617,623.61
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(10,115,349.48)	00.00	(10,115,349.48)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,767,655,847.77	3,037,564,576.34	(986,718,149.98)	00.00	4,818,502,274.13

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,983,959,600.00	2,690,121,013.67	293,838,586.33	90.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,983,959,600.00	2,690,121,013.67	293,838,586.33	90.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,775,993,700.00	2,503,438,533.67	272,555,166.33	90.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,121,800,300.00	2,049,161,207.64	72,639,092.36	96.6
210101	Үндсэн цалин	1,082,333,600.00	1,110,822,043.79	(28,488,443.79)	102.6
210102	Нэмэгдэл	874,764,900.00	835,034,451.85	39,730,448.15	95.5
210104	Урамшуулал	164,701,800.00	103,304,712.00	61,397,088.00	62.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	301,214,500.00	250,933,678.74	50,280,821.26	83.3
210201	Тэтгэврийн даатгал	204,825,900.00	177,598,103.40	27,227,796.60	86.7
210202	Тэтгэмжийн даатгал	24,097,200.00	18,768,396.86	5,328,803.14	77.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,277,700.00	13,157,894.35	6,119,805.65	68.3
210204	Ажилгүйдлийн даатгал	4,819,400.00	3,171,423.14	1,647,976.86	65.8
210205	Эрүүл мэндийн даатгал	48,194,300.00	38,237,860.99	9,956,439.01	79.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	116,967,500.00	86,029,440.29	30,98,059.71	73.5
210301	Гэрэл, цахилгаан	32,300,000.00	20,009,267.00	12,290,733.00	61.9
210302	Түлш, халаалт	56,780,500.00	46,744,108.29	10,036,391.71	82.3
210303	Цэвэр, бохир ус	27,887,000.00	19,276,065.00	8,610,935.00	69.1
2104	Хангамж, бараа материалын зардал	47,902,800.00	31,443,987.00	16,458,813.00	65.6
210401	Бичиг хэрэг	4,530,600.00	4,530,595.00	5.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	13,973,000.00	5,149,800.00	8,823,200.00	36.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,803,500.00	3,595,320.00	208,180.00	94.5
210404	Ном, хэвлэл	3,334,000.00	00.00	3,334,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,816,900.00	3,528,720.00	1,288,180.00	73.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,444,800.00	14,639,552.00	2,805,248.00	83.9
2105	Нормативт зардал	89,486,900.00	33,478,500.00	56,008,400.00	37.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,526,500.00	5,342,070.00	3,184,430.00	62.7
210502	Хоол, хүнс	74,576,100.00	21,870,630.00	52,705,470.00	29.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,384,300.00	6,265,800.00	118,500.00	98.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,880,000.00	20,427,700.00	7,452,300.00	73.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,480,000.00	3,278,000.00	5,202,000.00	38.7
210604	Урсгал засвар	19,400,000.00	17,149,700.00	2,250,300.00	88.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,963,000.00	25,931,270.00	24,031,730.00	51.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,592,900.00	24,302,000.00	22,290,900.00	52.2
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	278,820.00	21,180.00	92.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	492,000.00	484,200.00	7,800.00	98.4

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	492,000.00	00.00	492,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,086,100.00	866,250.00	1,219,850.00	41.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,778,700.00	6,032,750.00	14,745,950.00	29.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,823,200.00	00.00	8,823,200.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,955,500.00	6,032,750.00	5,922,750.00	50.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	207,965,900.00	186,682,480.00	21,283,420.00	89.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	207,965,900.00	186,682,480.00	21,283,420.00	89.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,757,800.00	23,384,380.00	17,373,420.00	57.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	162,698,100.00	162,698,100.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,510,000.00	600,000.00	3,910,000.00	13.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,983,959,600.00	2,690,121,013.67	293,838,586.33	90.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,983,959,600.00	2,689,196,446.67	294,763,153.33	90.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,983,959,600.00	2,689,196,446.67	294,763,153.33	90.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	924,567.00	(924,567.00)	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	924,567.00	(924,567.00)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	0.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
62	АЖИЛАГСДЫН ТОО	150	140	10	93.3
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	88	78	10	88.6
620003	Үйлчлэх ажилтан	61	61	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,697,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,697,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,552,100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,547,500.00
210104	Урамшуулал		1,547,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,004,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,004,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		0.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		145,500.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		145,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		2,697,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,697,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		625,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,072,600.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Д.Оюунсувд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдлийг бүрдүүлж ажиллах, архив, албан хэрэг хөтлөлтийг хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 12 дугаар сарын 25-наас 2021 оны 2 дугаар сарын 05-ны хооронд эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Эс Жи Эм Ди Аудит” ХХК-ийн аудитор Д.Жаргалсайхан, Б.Оюунцэцэг, О.Алтанцэцэг, Ч.Ням-Очир нар хариуцаж хэрэгжүүлэв.

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тусгай хэрэгцээт боловсролыг бага боловсролын түвшинд олгох /1-5 анги/
- Тусгай хэрэгцээт боловсролыг суурь боловсролын түвшинд олгох /6-9 анги/
- Тусгай хэрэгцээт боловсролыг бүрэн дунд боловсролын түвшинд олгох /10-12 анги/

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Засгийн газрын 2020.02.28-ны 78 дугаар тогтоол
- Засгийн газрын 2020.03.27-ны 114 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2020.04.15-ны 139 дүгээр тогтоол
- Засгийн газрын 2020.05.06-ны 168 дугаар тогтоол
- Засгийн газрын 2020.11.18-ны 183 дугаар тогтоол
- Засгийн газрын 2020.11.23-ны 188 дугаар тогтоол

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургууль санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

БШУЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,144,654.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 31,446.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,115.3 мянган төгрөгөөр буюу 0.20 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	924.6	0.0	(924.6)
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	82,232.0	91,747.1	9,515.1
Үндсэн хөрөнгө	4,745,461.0	4,726,755.2	(18,705.8)
Нийт хөрөнгө	4,828,617.6	4,818,502.3	(10,115.3)
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,828,617.6	4,818,502.3	(10,115.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,828,617.6	4,818,502.3	(10,115.3)

Авлага дансны үлдэгдэл 924.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд авлагыг барагдуулж үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 91,747.1 мянган төгрөг болж 9,515.1 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 2019-2020 онд худалдан авч нөөц үүсгэсэн 9,125.3 мянган төгрөгийн бичиг хэрэг, аж ахуйн болон шатах тослох материалууд байна.

Энэ нь төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан, хэрэгцээгээ оновчгүй тодорхойлж бараа материал бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,726,755.2 мянган төгрөг болж 18,705.8 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 160,616.3 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 4,454.9 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 25,818.2 мянган төгрөгөөр хөрөнгөөр нэмэгдсэнийг байгууллагын захирлын 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/47, 12 дугаар сарын 15-ны өдрийн А/49 тушаалуудаар хөрөнгөнд бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,818,502.3 мянган төгрөг болж 10,115.3 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлээс шалтгаалжээ.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 150,012.1 мянган төгрөгөөр буюу 5.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хандив тусламж, урсгал үйл ажиллагааны санхүүжилт, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогууд байна. Энэ нь төсвийн төлөвлөлт, Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөлт гарсан байна.

Нийт зардал өмнөх оноос 16,753.6 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлууд байна. Энэ нь цалингийн зардлаас шалтгаалан өөрчлөлт гарсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 976,602.8 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь өмнөх оны тайлант хугацааны үр дүнгийн өсөлтөөс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,319,811.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,319,811.3 тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 355,304.7 мянган төгрөгөөр бууруулж 2,964,506.6 мянган төгрөгөөр баталсан байна. 2020 оны төсвийн төсөл нь 2019 оны батлагдсан төсвөөс 355,304.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн бөгөөд цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэл, байр ашиглалтай холбоотой тогтмол зардал, урсгал шилжүүлэгийн зардлуудыг нэмэгдүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,964,506.6 мянган төгрөгийн төсөв баталснаас, улсын төсвөөс 100 хувь санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,984,884.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,690,121.0 мянган төгрөгийг зарцуулж 294,763.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,690,121.0 мянган төгрөг буюу 90.1 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 72,639.1 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэлийн зардлыг 50,280.1 мянган төгрөгөөр, байр ашиглалтай холбоотой тогтмол зардлыг 30,938.1 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 16,458.9 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 56,008.4 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 7,452.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 24,031.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 14,746.0 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэгийг 21,283.4 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь тусгай хэрэгцээт боловсролын хөтөлбөрийн тусгай хэрэгцээт боловсрол олгох арга хэмжээг 294,763.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна. Тайлант онд дэлхий нийтийг хамарсан цар тахал өвчнөөс шалтгаалан улс орны хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлснээс хичээл сургалтын үйл ажиллагааг зогсоосонтой холбоотойгоор зарим зардлууд зарцуулагдаагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 625.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,072.6 мянга, нийт 2,697.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин урамшуулалд 1,547.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,004.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 145.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 169 мэдээллээс хугацаандаа оруулсан 122 мэдээлэл, хугацаа хоцроосон 33 мэдээлэл, 14 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Шилэн дансны мэдээлэлд 5.0 сая төгрөгнөөс дээш орлогын гүйлгээ болон хуулийн багц үйлчилгээ авсан 9,000.0 мянган төгрөг, ус халаалтын бойлуурын үнэ 9,821.0 мянган төгрөг, бойлуурын ажлын хөлс 6,579.0 мянган төгрөг, камер солиулсан 5,831.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээнүүдийг шилэн дансанд байршуулаагүй байна. Мөн шилэн дансны мэдээлэлд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн ямар нэгэн тушаал шийдвэрийг оруулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 153,823.9 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлснээс, 13,772.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг биелүүлсэн, 140,051.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлээгүй байна. Аудитаар өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

мянган төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	3	153,823.9	2	13,772.3	1	140,051.6	91.0
Зөвлөмж	3	-	3	-	-	-	-
Нийт дүн	6	153,823.9	5	13,772.3	1	140,051.6	

Өмнөх тайлант оны биелүүлээгүй 140,051.6 мянган төгрөгийн албан шаардлагад Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасны дагуу холбогдох албан тушаалтанд албан шаардлага хүргүүлэв.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 403,308.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 167,379.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 233,454.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 2,475.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. 16,489.7 мянган төгрөгийн үнэлгээтэй дулааны бойлуурыг шууд зардалд бүртгэсэн бөгөөд, уг хөрөнгийг бараа материалын дансанд бүртгээгүй байна.
2. Тайлант хугацаанд нэмэгдсэн 150,889.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулгын хэсэгт тусгаагүй байна.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 230,177.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс, дээрх зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Байгууллагын тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулаагүй, хэрэгцээт 230,177.6 мянган төгрөгийн хоол хүнсний материал худалдан авах болон үдийн цайны үйлчилгээний тендерийг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 46 дугаар зүйлийн 46.1.4 “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах;”, 48 дугаар зүйлийн 48.5 “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.”, УСНББОУС1-ийн 27 зүйл: “үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг.” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгөх

2. Шилэн дансны 34 мэдээллийг хугацаа хоцроож, 17 мэдээллийг оруулаагүй, 31,231.2 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байгаа зөрчил нь Шилэн дансны тухай хууль 3.1-д заасан “Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна.” 3.1.1-д заасан “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд,” гэсэн заалтууд, УСНББОУС1-ийн 27 дугаар зүйл: “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг.” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгөх

3. Тээвэр шатахууны зардлыг бодит хэрэгцээнээс илүү төлөвлөн, тайлант хугацааны эцэст худалдан авалт хийж, 3,276.8 мянган төгрөгийн үлдэгдэл нөөцийг өмнөх жилийн төсвөөс бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т заасан “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих,” заалт, УСНББОУС1-ийн 29 дүгээр зүйл: “Бараг бүх нөхцөл байдалд байгууллага нь тохирох УСНББОУС-ыг даган мөрдсөнөөр үнэн зөв толилуулгад хүрдэг., Хамааралтай, үнэн зөв илэрхийлэх, ойлгомжтой, цаг хугацаандаа, зэрэгцүүлэгдэх, шалгаж болох мэдээллээр хангах байдлаар мэдээллийг, үүн дотроо нягтлан бодох бүртгэлийн бодлогыг толилуулах.” заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 2,475.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХҮЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Тайланд онд тус байгууллагын нягтлан бодогч нь 4 удаа солигдсон нөхцөл байдал, сургуулийн заал ашиглалттай холбоотой байгуулсан гэрээ, орлого, дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх, цалин хөлсний тушаал шийдвэр гэх мэт төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Санхүүгийн программаар 2,475.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй хүнсний материалын тайлан, тооллогын баримтууд байхгүй, үдийн цай, үдийн хоолны болон дотуур байрны хүүхдийн хоолны материалын технологи карт, захиалгын хуудас, шаардах хуудас зэрэг маягтуудыг буруу хөтөлсөн, дутуу хийсэн байна. Түлш шатахууны тооцоог карт болон талонаар хийдэг. Харилцах дансны гүйлгээг баримттай тулган баталгаажуулж шалгахад сар бүр мөнгөн хөрөнгийн тайланг хөтлөөгүй, баримтыг эмх цэгцгүй үдсэн.

1.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, стандартыг хэрэгжүүлж ажиллаагүй нь хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт сулрах, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгасан байх;

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчиж байгаа бөгөөд анхан шатны баримтын үнэн зөв, цаг тухайд нь бүрдүүлж байх, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж ажиллах,

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хоол хүнс, үдийн цайны хоолны материалыг технологийн картын дагуу хөтлөн ажиллахын тулд мэргэжлийн хоол зүйч ажиллуулан норм нормативын дагуу технологийн карт хөтлөн захиалгын хуудсыг тооцооны нягтлан бодогчоор тухай бүрт нь бодуулан ахлах нягтлан бодогчид хянуулан ажиллана.Тээвэр шатахууны зарцуулалтыг авто машины км-ийн заалтыг тулган хэмжилт хийж үлдэгдлийг баталгаажуулан тулгалт хийж ажиллана.

Хүнсний материалын тайлангийн 9,10,11 сарын тооллогыг баримтанд хавсаргаж хийсэн. Захиалгын дагуу авсан хоолны материалын шаардах хуудсыг баримтанд хавсаргаж хийсэн. Үдийн хоолонд орсон сурагчдын ирцийн бүртгэлийг өдөр бүрээр нь хуулбарлан баримтанд хавсаргасан.

Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 225/296 тоот тушаалын дагуу ахлах тогооч технологийн картыг шинэчлэн хийсэн. Цаашид 2021 оны тайлан, тооцоог нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу хийж ажиллана.

2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Байгууллагын нийт баримтуудыг үдэж архивласан ч баримтын доторх огноо дугаар алдагдсан, цахим архивыг бүрдүүлээгүй байна. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлээгүй байна.

2.2 Эрсдэл:

Архивын хууль, журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байх, энэ нь байгууллагын архивын сан хөмрөгийн баримтыг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах, хяналт тавих, ашиглах болон албан хэрэг хөтлөлтийг дутуу, буруу хөтөлсөн байх үр дагавартай.

2.3. Өгсөн зөвлөмж:

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23.1-т "Байгууллагын архив тухайн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж, архивын баримтыг анхан шатанд бүрдүүлж, энэ хуульд заасан хугацаагаар түр хадгална." гэсэн заалтыг зөрчиж байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт тавин ажиллах,

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Баримтуудыг архивын дүрэм журмын дагуу үдэж, цаашид цахим архив үүсгэн, дүрэм журмын дагуу ажиллах болно. 2021 оны 1,2 дугаар улиралд багтаан Дотоод хяналт шалгалтыг бусад үйл ажиллагаанд хийхээр төлөвлөгөөнд тусган, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг шинэчлэн батлуулж ажиллана. 2021 оны 1 дүгээр сард багтаан ажлын байрны тодорхойлолт боловсруулж, батлуулж ажиллана.

3.Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Ковид-19 цар тахлын нөхцөл байдал, хорио цээрийн дэглэм тогтоосон үеийн ажиллаагүй ажиллагсдын цалинг бодож олгохдоо 8,031.0 мянган төгрөгийн хоол, унааны мөнгийг тооцож олгосон байна.

3.2 Эрсдэл:

Ковид 19 нөхцөл цар тахлын байдлын үед хөл хорио тогтоосонтой холбоотойгоор ажилчдад цалинг олгохдоо унаа, хоолны мөнгийг олгосон байгаа нь төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах, холбогдох тогтоол, журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байх, ажилчдаас авлага үүсэх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,

3.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль "20.2.4.нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;" "20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах,

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Ковид-19 цар тахлын халдвар хамгааллын үед теле хичээлийн дохионы хэлний орчуулганд багш нар туслах багшийн хамт орчуулагч багшаар ажилласан. Захиргаа аж ахуйн ажиллагсад халдвар хамгаалал, ариутгал халдваргүйжүүлэлт хийн бэлэн байдалд ажилласан. /Багш нарын цахим хичээл заасан баримтыг хасвралтаар хавсаргав./

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.15	Аудитын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/160/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 29-р сургууль ТШЗ	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуул-лагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Байгууллагын тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулаагүй, хэрэгцээт 230,177.6 мянган төгрөгийн хоол хүнсний материал худалдан авах болон үдийн цайны үйлчилгээний тендерийг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.	230,177.6	Албан шаардлага	Захирал, Ахлах нягтлан бодогч	Д.Оюунсүвд, Л.Мөнхгэрэл
2	Тээвэр шатахууны зардлыг бодит хэрэгцээнээс илүү төлөвлөн, тайлант хугацааны эцэст худалдан авалт хийж, 3,276.8 мянган төгрөгийн үлдэгдэл нөөцийг өмнөх жилийн төсвөөс бэлтгэсэн байна.	3,276.8	Албан шаардлага	Захирал, Ахлах нягтлан бодогч	Д.Оюунсүвд, Л.Мөнхгэрэл
3	Шилэн дансны хуулийн хэрэгжүүлж ажиллагаагүй, шилэн дансанд хуулиар оруулах мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, зарим мэдээллийг оруулаагүй байна.	-	Албан шаардлага	Захирал, Ахлах нягтлан бодогч	Д.Оюунсүвд, Л.Мөнхгэрэл
4	Ковид-19 цар тахлын нөхцөл байдал, хорио цээрийн дэглэм тогтоосон үеийн ажиллаагүй ажиллагсдын цалинг бодож олгохдоо 8,031.0 мянган төгрөгийн хоол, унааны мөнгийг тооцож олгосон байна.	-	Зөвлөмж	Захирал, Ахлах нягтлан бодогч	Д.Оюунсүвд, Л.Мөнхгэрэл
5	Санхүүгийн программаар 2,475.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй хүнсний материалын тайлан, тооллогын баримтууд байхгүй, үдийн цай, үдийн хоолны болон дотуур байрны хүүхдийн хоолны материалын технологи карт, захиалгын хуудас, шаардах хуудас зэрэг маягтуудыг буруу хөтөлсөн, дутуу хийсэн байна. Түлш шатахууны тооцоог карт болон талонаар хийдэг. Харилцах дансны гүйлгээг баримттай тулган баталгаажуулж шалгахад сар бүр мөнгөн хөрөнгийн тайланг хөтлөөгүй, баримтыг эмх цэгцгүй үдсэн.	2,475.1	Зөвлөмж	Захирал, Ахлах нягтлан бодогч	Д.Оюунсүвд, Л.Мөнхгэрэл
6	Байгууллагын нийт баримтуудыг үдэж архивласан ч баримтын доторх огноо дугаар алдагдсан, цахим архивыг бүрдүүлээгүй байна. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлээгүй байна.	-	Зөвлөмж	Захирал, Ахлах нягтлан бодогч	Д.Оюунсүвд, Л.Мөнхгэрэл
ДҮН		235,929.5			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 20/A0170069
САГ-2021/160/СТА-ТЧЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулаагүй, 230,177.6 мянган төгрөгийн хоол, хүнсний материал худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ", 46 дугаар зүйлийн 46.1.4-т "худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах", 48 дугаар зүйлийн 48.5-д "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж, зөрчлийг арилган биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн захирал Д.Оюунсүвд, ахлах нягтлан бодогч Л.Мөнхгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.ДАШДАВАА

Д.ЭХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\0.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2021\0225auditin 2-R Газар6.Docx

001081035



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 21/A0170059

Улаанбаатар хот

САГ-2021/160/СТА-ТУЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансанд оруулбал зохих 169 мэдээллээс хугацаа хоцроосон 33 мэдээлэл, мөн 14 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:”, 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр,” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн захирал Д.Оюунсүвд, ахлах нягтлан бодогч Л.Мөнхгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.ДАШДАВАА

Д.ЭХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2021\0225auditin 2-R Gazar7.Docx

001081038



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 22/10170059
САГ-2021/160/СТА-ТЧЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тээвэр шатахуун, нормативт зардлыг бодит хэрэгцээнээс илүү төлөвлөн, тайлант хугацааны эцэст худалдан авалт хийж, 3,276.8 мянган төгрөгийн үлдэгдэл нөөцийг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг бодитой бус төлөвлөж, зарцуулж тайлагнасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 29 дүгээр сургуулийн захирал Д.Оюунсүвд, ахлах нягтлан бодогч Л.Мөнхгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.ДАШДАВАА

Д.ЭХБАЯР

[illegible]

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The entire page is otherwise blank, with no margins, text, or other markings.